

## МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

### Хоёр. Мэргэшлийн зөвлөл

2.1. Мэргэшлийн зөвлөл нь Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах, мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж буй Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.

2.2. Мэргэшлийн зөвлөл нь орон тооны бус есөн гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хорооноос томилно.

2.3. Мэргэшлийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн хурлаар томилно.

2.4. Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Хорооны Үнэт цаасны газрын болон сургалт зохион байгуулагч, үнэт цаасны чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой багш судлаачдын төлөөлөл орж болно.

2.5. Мэргэшлийн зөвлөлийн хуралдаан нь нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.6. Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.6.1. мэргэшлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулах;

2.6.2. мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах, нийтэд мэдээлэх;

2.6.3. мэргэшлийн зөвлөлийн хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хуралдаанд хэлэлцэх асуудлын жагсаалтыг Мэргэшлийн зөвлөлийн даргаар батлуулж, хэлэлцэх бичиг баримтын хамт гишүүдэд хүргүүлнэ.

### Гурав. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

3.1. Мэргэжилтний эрх олгох болон аттестатчилах мэргэшлийн сургалт, шалгалттай холбоотой өргөдлийг Мэргэшлийн зөвлөл хүлээн авч, шийдвэрлэнэ.

3.2. Шалгуулагч шалгалтын дүнтэй санал нийлэхгүй, шалгалтын тесттэй холбоотой өргөдлийг шалгалтын дүн зарлагдсанаас хойш ажлын гурван хоногт багтаан Мэргэшлийн зөвлөлийн даргад бичгээр ирүүлнэ.

3.3. Мэргэшлийн зөвлөл өргөдлийг ажлын гурван өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

3.4.Шалгалтын дүнтэй холбогдсон маргаан гарвал Мэргэшлийн зөвлөлийн дарга магадлах ажлын хэсгийг томилон, материалыг дахин шалгуулах эрхтэй бөгөөд тухайн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Мэргэшлийн зөвлөл шийдвэр гаргана.

3.5.Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй.

ooOoo